

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2021 ОНЫ БИЕЛЭЛТ**

Иргэний нисэхийн ерөнхий газар

2022.01.28

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	2021 оны зорилтот түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1.	<b>1 дүгээр зорилт</b> Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн албан сонгон жинхэнэ хаагчийн шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	4.1.1.1.1.Төрийн зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	2017-2022 он	Мэдээллийн журмыг системүүдийн журмыг боловсруулж, батлуулсан байх, баяжуулах тогтолцоо бүрдсэн байх	2021 онд АТГ-аар хянуулсан 74 ХАСУМ-ийг байгууллагын цахим хуудасны <a href="https://www.mcaa.gov.mn/?p=1364Z">https://www.mcaa.gov.mn/?p=1364Z</a> -д байршуулж нийтэд ил тод болгосон. Тус байгууллагын ажилтнууд нь төрийн жинхэнэ албан хаагч биш тул шинээр ажилд томилоход Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт гаргадаггүй болно.	100%
2.		4.1.1.1.5.Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	2017-2022 он	Мэдээллийн сангийн журмыг боловсруулж батлуулсан байх, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байх тогтолцоо бүрдсэн байх	Байгууллагын ажилтнуудын жагсаалт болон дотуур утасны жагсаалтыг цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдал хуудсанд байршуулсан. 2017-2021 онд агентлагийн ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын нэрсийг он тус бүрээр гаргаж, байгууллагын цахим хуудсанд <a href="https://www.mcaa.gov.mn/?p=673Z">байршуулсан. https://www.mcaa.gov.mn/?p=673Z</a>	100%
3.		4.1.1.2.1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2017-2022 он	Шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байх Шалгуурт нийцсэн ТЖАХ-ийн эзлэх хувь - 80%-аас дээш	Ажилтнуудыг ажилд авах, дадлагажуулахдаа тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 3.5.1 дэх заалтыг мөрдөж байна. ИНЕГ-ын даргын 2021.01.27-ны өдрийн А/18 дугаар тушаалаар "Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам"-ыг шинэчлэн баталсан. Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулж, ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021.08.31-	100%

					<p>ний өдрийн А/108 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдөж байна. ИНЕГ: 2021.12.01-ний өдрийн байдлаар агентлагийн хэмжээнд 7 ажилтныг сул ажлын байранд шинээр ажилд авсан. Үүнд: ХДЖ-ын 3.5.1.1 дахь заалтын дагуу 2 ажилтныг, 3.5.1.2 дахь заалтын дагуу 5 ажилтныг шинээр ажилд авсан. Салбартаа 2-оос дээш жил ажилласан 17 ажилтныг шилжүүлэн томилсон бөгөөд үүнээс 7 ажилтныг албан тушаал дэвшүүлэн томилсон. 2021 онд агентлагийн хэмжээнд 5 ажлын байрыг нийтэд н-ээлттэй зарласан. ИНУТ: 2021.12.01-ний өдрийн байдлаар нийт 159 сул орон тоонд холбогдох хууль, журмын дагуу шинээр ажилтан авч ажиллуулсан. Үүнээс: Сонгон шалгаруулалтаар 11, Хөдөлмөрийн дотоод журмын 3.5.1 дэх заалтын дагуу 148 орон тоог нөхсөн.</p> <p>Сул ажлын байрны зарыг нийтэд ил тод мэдээлэх зорилгоор байгууллагын цахим хуудсанд <a href="https://www.mcaa.gov.mn/?p=3033">https://www.mcaa.gov.mn/?p=3033</a>-д байршуулж байна.</p> <p>ИНЕГ-ын даргын 2021.03.30-ны өдрийн А/43 дугаар тушаалаар "Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-ыг шинэчлэн баталсан. Энэ журамд ажилтнуудын тухайн жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дэвшүүлэх, шөгнөж, урамшуулах, цалингийн шатлалыг ахиулах талаар тусгагдсан. ИНЕГ-ын даргын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны хүний нөөцийн үйл ажиллагаанд аудит, шалгалт хийсэн.</p>
--	--	--	--	--	--

					<p>НААХЗА-ны байцаагч нарын албан тушаалын тодорхойлолтод Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын DOC9734 баримт бичгийн зөвлөмж, шаардлагыг тусган, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулсан. Агаарын навигац, нисэх буудлуудын хүний нөөцийн үйл ажиллагаанд аудит шалгалтыг ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 11 нэгж/ИНУТ, түүний харьяа алба/, 15 орон нутгийн нисэх буудалд хийлээ. Навигац, газрын тусгай үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр 689 ажилтны, нисэх буудлын чиглэлээр 402 ажилтны албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг нягтлан, нэгжийн ажилтнуудын сонгон шалгаруулалт, шатлан дэвших тогтолцоог бүрдүүлж буй байдлыг шалгаж илэрсэн үл тохирлыг засч залруулахаар 21 зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж байна.</p>			
4.	4.1.1.9.1.Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	2017-2022 он	-	ИНЕГ-ын хэмжээнд албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын iMCAA системийг 2021 онд нэвтрүүлсэн. "Тридиум" ХХК-аас 50 ширхэг тоон гарын үсэг худалдан авч холбогдох албан тушаалтнуудад олгосон. iMCAA системд тус компаниас авсан тоон гарын үсгүүдийг АРГ-аар холбож, албан хэрэг хөтлөлтийг бүрэн цахимжуулсан. Ингэснээр нийтийн түлхүүрийн дэд бүтцийн системд холбогдсон. Уг системд холбогдсон байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан цахим албан бичиг солилцох боломжтой болсон.	100%			
5.	4.1.1.10.3.Авлигын эсрэг сургалт, Давтан сургалтыг зохион-байгуулах	2018-2022 он	-	АТГ-аас 2021 онд тус байгууллагад зохион байгуулуулах сургалтын саналаа 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/144 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлж, 2021 оны 6 дугаар	100%			

6.	<p><b>2 дугаар зорилт</b> Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, үйлчилгээг хөгжүүлж хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх</p>	<p>4.1.2.4.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	2018-2022 он	-	<p>сарын 16-нд сургалтыг цахимаар зохион байгуулж, 138 ажилтанг хамруулсан. Мөн АТГ-аас 11,12 сард зохион байгуулах анхан шатны болон давтан сургалтад хамруулах ажилтнуудын нэрсийн жагсаалтыг гаргаж, 2021.11.03-нд АТГ-т хургуулсан. 2021.12.01-ний өдрийн байдлаар 64 ажилтан сургалтад хамрагдаад байна. 2021 онд 282 ажилтанг сургалтад хамруулсан.</p>	100%
<p>ИНЕГ-аас үзүүлэх төрийн үйлчилгээнүүд болох нисэхийн аюулгүй ажиллагааны үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлт, нислэгийн хуваарийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлсэн. Эдгээр мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг ИНЕГ-ын Мэдээллийн технологи, хөгжлийн алба хариуцан дотоод нөөц бололцоогоор хийсэн тул ямар нэгэн хүндрэл гараагүй. Нисэхийн аюулгүй ажиллагааны гэрчилгээжүүлэлтийн мэдээллийг цахимжуулах зорилгоор 13 модуль бүхий "ЦАХИМ НААХЗА" системийг 2 үе шаттай хэрэгжүүлж, бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. 1-р үе шатны 7 модулийн хөгжүүлэлтийг хийж, НААХЗА-ны байцаагч, мэргэжилтнүүдтэй төслэж дууссан. 2-р үе шатны 6 модулийг 2022 оны 3 дугаар улиралд бүрэн ашиглалтад оруулахаар программ хангамжийн хөгжүүлэлтийг гүйцэтгэж байна. Нисэхийн аюулгүй ажиллагааны үнэмлэхжүүлэлтийн мэдээллийг цахимжуулсан "eYнэмлэх" системийг 2021 онд үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. Нислэгийн хуваарийн мэдээллийг "eMongolia" төрийн үйлчилгээний нэгдсэн порталд нэгтгэсэн. Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийг eMongolia-д нэгтгэхээр ХХМТГ-т хургуулсан</p>						

7.		4.1.2.2.3 зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	2018-2022 он	-	<p>боловч энэ үйлчилгээ нь тодорхой хэрэглэгчид чиглэсэн, зөвхөн нислэгч, нислэгийн удирдагч, агаарын тээвэрлэгчид компанид зориулагдсан, нийтэд хүртээмж багатай тул 2021 онд нэгтгэх шаардлагагүй, 2022 оны 2 дугаар хагаст e-mongolia системд нэгтгэх төлөвлөгөөнд тусгасан гэсэн хариуг 2021.12.09-ний өдрийн 04/1283 тоот албан бичгээр ХХМТГ-аас өгсөн.</p> <p>Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан "Аюулгүй ажиллагааны хяналт"-ын дос 9734-ын 2.3.1-д "ажилтнуудын үнэмлэх, гэрчилгээжүүлэлт, агаарын хөлөг, агаарын тээвэрлэгч, аэродромын гэрчилгээжүүлэлтийн ажлыг зохион байгуулах нь Чикагогийн конвенц, түүний хавсралтуудад заасны дагуу тухайн Улсын үүрэг байна" гэж заасан. Мөн дос 9734-ын 3.2.4-т Нисэхийн гол/үндсэн хууль тогтоомжид "Иргэний агаарын тээврийн үйл ажиллагааг идэвхтэй хянах, зохицуулах ялангуяа агаарын хөлгийн ашиглалт, түүнийг бүртгэх, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хариуцан хэрэгжүүлэх байгууллага буюу ИНЕГ-ыг хуульчилсан зохицуулалтыг тусгасан байх ёстой" гэж заасан. Олгож буй тусгай зөвшөөрөл нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл бөгөөд Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2-т "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон байдлыг хангуулахад чиглүүлнэ" гэж заасан. Мөн Чикагогийн конвенцид нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй ажиллагааны</p>	Үнэлэх боломжгүй.
----	--	---	--------------	---	---	-------------------

8.		4.1.2.4.3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2018-2022 он	-	<p>стандарт буюу нисэхийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг нарийвчлан тодорхойлсон, иргэний нисэхийн багц дүрмийн хүрээнд салбарын зохицуулалтыг хийдэг бөгөөд иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгчид зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагааг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, эрх шилжүүлэх нь одоогийн байдлаар боломжгүй байна.</p> <p>Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас тавьж байгаа аюулгүй ажиллагааны хяналт нь аюулгүй ажиллагаатай холбогдолтой хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, гэрчилгээжсэн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгддөг баримт бичгүүдэд хяналт тавих, аюулгүй ажиллагаа хангагдсан байдалд үзлэг шалгалт явуулах, дүрмийн дагуу үнэмлэхжүүлэх зэрэг хэлбэрээр хийгддэг. Түүнээс гадна осол, ноцтой зөрчил, зөрчил, эмтэл саатал, дутагдалд үзлэг шалгалт хийх замаар давтан гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна. Монгол Улс 1989 онд нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцоор гишүүн улс бүр нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт шалгалтын чухал 8 элементийг нэвтрүүлэх, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад нисэхийн аюулгүй ажиллагааны байнгын хяналт шалгалтыг хийх замаар хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эд хөрөнгөд хохирол үүсэхээс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээсэн. Одоогийн байдлаар Чикагогийн конвенцийн Хавсралтуудын шаардлагын дагуу боловсруулж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн</p>	Үнэлэх боломжгүй.
----	--	--	--------------	---	---	-------------------

					<p>баримт би-ниг бүртгэгдсэн, нисэхийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тодорхойлсон 52 иргэний нисэхийн багц дүрмийн хэрэгжилтэд хийж буй хяналт, шалгалтын тоог бууруулах боломжгүй бөгөөд бууруулсан нөхцөлд олон улсын өмнө хүлээсэн үүргээ зөрчих нөхцөл байдал үүснэ. Цаашдаа Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх, хяналт шалгалтын чанарыг дээшлүүлэхийн тулд зөвхөн болсон үйл явдалд дүн шинжилгээ хийж ажиллах бус урьдчилсан дүн шинжилгээ хийж ажилладаг тогтолцоог иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал: Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчид иргэний нисэхийн дүрмээр, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байх шаардлагыг тавьж, хэрэгжилтэд хяналт тавьж байна. Мөн Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр (State Safety Program) -ийг Зам тээвэр, хөгжлийн сайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын орчны цогц үйл ажиллагааг программ хангамжийн дэвшилтэт шийдлийн тусламжтайгаар хялбаршуулах, системчлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн урсгалыг сайжруулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлснээр гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтыг оновчтой төлөвлөж зохион байгуулах, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай хүргэх хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх боломжийг олгоно. Тухайлбал: Механик, цаасан суурьтай хийгддэг ажлуудыг багасган,</p>
--	--	--	--	--	--

9.		4.1.2.7.1.Төрийн үйлчилгээний хүртээмжид чанар, хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	2017-2022 он	-	<p>бүтээмжээ нэмэгдүүлэх, цаг хугацаа хэмнэх, үйл ажиллагааг ил тод болгох, аливаа мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийх, цаашилбал иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны ухаалаг хяналтын бодлого, стратегийг тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ. Мөн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ шаардлагатай мэдээллийн сантай шууд холбогдох, дүн шинжилгээ хийх, баримтжуулалт, бүртгэл хийх, зөрчлийн бүртгэл үүсгэх, хугацаат шаардлага хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт цаг хугацаа хэмнэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүргээ чанартай, үр өгөөжтэй гүйцэтгэх боломжийг олгоно.</p>	70%
					<p>"Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл Саримтлах бодлого"-ын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлэх зардлыг ИНУТ-ийн 2021 оны төсөвт суулгасан. Үнэлгээ хийлгүүлэх ажлын даалгаврыг энэ оны 6 дугаар сарын 25-нд ИНЕГ-ын Дэд дарга баталсан. ИНУТ-ийн харьяа ХААТ хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлын эрхийг ТХААГ-т шилжүүлж, энэ оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 10-1/842 тоот албан бичгээр ажлын даалгаврыг хүргүүлсэн. ТХААГ-тендер зарлан тендерийг үнэлж, "Хүний хөгжил судалгаа сургалтын төв"-тэй ИНУТ-ийн дарга 2021.09.23-нд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн. Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020-2021 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлын удирдамжийг батлан, үнэлгээ хийлгүүлэхээр гэрээ байгуулах шатанд байна.</p>	



10.		4.1.2.7.2 Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх	2018-2019 он	-	ИНЕГ-ын дотоод аудит, дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах шатанд байна. Энэ журамд төрийн үйлчилгээ үзүүлж буй нэгжүүдийн үйл ажиллагааг үйлчилгээ авч байгаа байгууллагуудаар үнэлүүлэх талаар заалт тусгаж өгсөн.	70%
11.	7 дугаар зорилт Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих	4.1.7.3.1.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	2017-2019 он	-	Иргэний нисэхийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын жагсаалтыг гаргасан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4-д заасны дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, хөндлөнгийн хяналт тавиулах зорилгоор үнэлгээний хороонд салбарын мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж байна.Тус байгууллагаас боловсруулж байгаа дүрэм, журмын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулан, иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн саналыг хүлээн авах боломжийг <a href="https://www.mcaa.gov.mn/?p=629">https://www.mcaa.gov.mn/?p=629</a> Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцож, санал авч байна.	70%
12.		4.1.7.3.2 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод нээлттэй болгож нийтэд мэдээлэх	2018-2022 он	-	"Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх" үндэсний хорооны 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаан дээр Ерөнхий сайд төрийн байгууллагын зарим чиг үүрэг, үйлчилгээг мэргэжлийн төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломж нөхцөлийг судалж тодорхойлох чиглэл өгсний дагуу судалгаа хийж, мэдээллийг нэгтгэж, ЗТХЯ-нд хүргүүлсэн.	30%


13.	<p><b>10 дугаар зорилт</b>          Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх</p>	<p>4.1.10.1.4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах</p>	2017-2022 он	-	<p>АТГ-аас авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг хэрхэн боловсруулах талаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу ИНЕГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангасан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг уг асуудлыг хариуцсан нэгжүүдийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтэд байнга хяналт тавьж ажилласан. Мөн 2021 онд Авлигын эсрэг тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 11 дүгээр хавсралт Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн холбогдох заалтуудын хэрэгжилтэд 2021 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулж, холбогдох зөвлөмжийг нэгжүүдэд өгч, хэрэгжилтэд хяналт тавьсан. ИНЕГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө 2021 оны жилийн эцсийн байдлаар 88%-тай хэрэгжсэн.</p>	70%
Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p><b>Ололт:</b>          1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг байгууллагын төсөвт тусгасан.          2.ИНЕГ-ын дотоод үйл ажиллагааны ИМСАА нэгдсэн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.          3.Хүнд суртлыг багасгах, үйлчилгээг хурдан шуурхай хүргэх зорилгоор ИНЕГ-аас олгож байгаа тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг судалж, 2021 онд үнэмлэхжүүлэлтийн "eYнэмлэх" системийг нэвтрүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.          4.Албан хэрэг хөтлөлтийн ИМСАА, нисэхийн аюулгүй ажиллагааны "Цахим НААХЗА"-ийг ИНЕГ дотоод нөөц бололцоогоороо хөгжүүлж, бүрэн дижитал өгөгдлийн сантай болсон. Ингэснээр ИНЕГ-аас олгож буй тусгай зөвшөөрөл, албан хэрэг хөтлөлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох боломжтой болсон.          5.Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулж, ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021.08.31-ний өдрийн А/108 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдөж эхэлсэн.          6. Худалдан авах ажиллагааг нийтэд ил тод зарлах, тендерийн баримт бичиг, тендерийн урилгыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д байршуулж байна. 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 128 ажлаас давхардсан тоогоор 154 урилгыг байршуулсан.</p>					

	<p>7. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлсэн.</p> <p><b>Дугаардал:</b></p> <p>ИНЕГ-ын нэгжүүдийн ажлын уялдаа, холбоо сул байгаагаас тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрч хэрэгжээгүй. Байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих ажлыг холбогдох нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ч хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрч хэрэгжихгүй байна.</p> <p><b>Анхаарах асуудал:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1.Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх талаар судалж, шийдвэр гаргах;</li> <li>2.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангах;</li> <li>3.Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх;</li> <li>4.ИНЕГ-ын даргын 2021.03.30-ны өдрийн А/43 дугаар тушаалаар баталсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг сайжруулах.</li> </ol>
<b>Хэрэгжилт - 82.7%</b>	

Танилцсан:  
Дарга

Хянасан:  
ДАА-ны дарга

Боловсруулсан:  
ИНҮТ-ийн ЗХНГ-ын менежер

 /С.МӨНХНАСАН/

/Н.МӨНХСҮРЭН/

 /Д.СУВДАА